



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 88

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.а дах заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Нийслэлийн хөрөнгө оруулалтаар Мал эмнэлгийн хүрээлэнгийн барилга засварын ажлын хүрээнд бий болсон нийт 48,566,948.00 (дөчин найман сая таван зуун жаран зургаан мянга есөн зуун дөчин найман) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Мал эмнэлгийн хүрээлэнгийн хөрөнгөд капиталжуулан бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга Б.Мөнхбат, Мал эмнэлгийн хүрээлэнгийн захирал Б.Батцэцэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001331

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2022 оны... дугаар сарын...-ний өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

**МАЛ ЭМНЭЛГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт балансын үнэ (төгрөг)
1	Барилгын дээврийн их засвар	м.кв	1000	48,566,948.00
НИЙТ ДҮН				(хорин таван тэрбум есэн зуун хоёр сая жаран мянга долоон зуун гучин найман)